



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/58

Жаргалтхаан сум

**2025 онд сумын ойн сангаас мод бэлтгэх
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дахь заалт, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 3 дугаар хуралдааны 10-р тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын ойн сангаас 2025 онд мод бэлтгэн (ойн мэргэжлийн байгууллагатай) гэрээ байгуулан ажиллахыг “Өсөх уудам ХХК”-д зөвшөөрсүгэй.

2. Үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцсан нутаг дэвсгэрийн байгаль хамгаалагчдад мод бэлтгэх эрхийн бичиг, мод модон материалын гарал үүслийн гэрчилгээнд хяналт тавьж, ойн мэргэжлийн байгууллагын мод бэлтгэлд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажиллах, тайланг сар, улирлаар гаргаж холбогдох байгууллагад хүргэж ажиллахыг байгаль орчны хяналтын улсын байцаагч (Г.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.ГАНБАТ

